



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/148

Зуунмод

Г Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт  
лабораторийн үйл ажиллагааны зааврын тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, Гамшаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7<sup>1</sup> дүгээр зүйлийн 7<sup>1</sup>.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Нэг Өрх-Нэг шинжилгээ" Коронавируст халдвар /КОВИД-19/ илрүүлэх арга хэмжээний хүрээнд лабораторийн цэг байгуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн нэгдүгээр, холбогдох зардлын 15,565,450 (арван таван сая таван зуун жаран таван мянга дөрвөн зуун тавь) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гарахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д үүрэг болгосугай.

2. "Нэг Өрх-Нэг шинжилгээ"-ний зохион байгуулалт, бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Ц.Буманбуян), Зуунмод сумын Засаг дарга (Ч.Сарангэрэл) нарт даалгасугай.

3. Зуунмод сумын иргэдийн хөдөлгөөн, хэв журам сахиулахад хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Ганзориг)-т даалгасугай.

4. "Нэг Өрх-Нэг шинжилгээ" Коронавируст халдвар /КОВИД-19/ илрүүлэх арга хэмжээний хүрээнд лабораторийн цэгт ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтэнг сонгох, халдвар хамгаалал, стандартын мөрдөлтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (С.Мөнхтуяа), үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (У.Өлзийцэцэг) нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч дарга бөгөөд Онцгой байдлын газрын дарга, хурандаа (Н.Төмөрбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2021 оны  
08 дугаар сарын 07-ны өдрийн  
А/148 тоот захирамжийн 1-р хавсралт

**ЛАБОРАТОРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН  
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

**Багийн ахлагч:**

Б.Энхтуяа

-Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга

**Нарийн бичиг:-**

Б.Ган-Эрдэнэ

-Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн яаралтай тусламж, гамшгийн асуудал хариуцсан мэргэжилтэн

**Багийн зохицуулагч:**

Ч.Сарангэрэл

-Зуунмод сумын Онцгой комиссын дарга бөгөөд сумын Засаг дарга

**Гишүүд:**

Л.Түмэндэмбэрэл

-Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч

С.Эрдэнэчимэг

-Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч

Ж.Алтанцэцэг

-Зооноз халдварт өвчин тандалт сэргийлэлтийн төвийн дарга

Г.Батжаргал

-Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Б.Жигмэддорж

-Зуунмод сумын Номт 1 дүгээр багийн Засаг дарга

Н.Мөнх-Өнөр

-Зуунмод сумын Ланс 2 дугаар багийн Засаг дарга

Ш.Цэндсүрэн

-Зуунмод сумын Баянхошуу 3 дугаар багийн Засаг дарга

Ч.Одончимэг

-Зуунмод сумын Зүүндэлгэр 4 дүгээр багийн Засаг дарга

С.Очирбат

-Зуунмод сумын Нацагдорж 5 дугаар багийн Засаг дарга

Б.Отгонбаяр

-Зуунмод сумын Баруун Зуунмод 6 дугаар багийн Засаг дарга

Б.Энхжаргал

-Баруун-Зуунмод өрхийн Эрүүл мэндийн төвийн дарга

Аймгийн Засаг даргын 2021 оны  
03 дугаар сарын 04 -ны өдрийн  
А/178 тоот захирамжийн 3-р хавсралт



**“НЭГ ХААЛГА-НЭГ ШИНЖИЛГЭЭ” ӨРХ БҮРЭЭС ШИНЖИЛГЭЭ  
 АВАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**1. Шинжилгээ авах байршлууд:**

№	Багийн нэр	Өрхийн тоо	Шинжилгээ авах байршил	Шинжилгээ авах хуваарьт өдрүүд
1	1-р баг	1354	Автобус /явуулын/	2021.03.08
2	2-р баг	825	Багийн байр	2021.03.09
3	3-р баг	512	Багийн байр	2021.03.09
4	4-р баг	389	4-р сургууль	2021.03.09
5	5-р баг	881	Спорт цогцолбор	2021.03.08
6	6-р баг	875	Солонго цогцолбор	2021.03.09

**2. Ажиллах боловсон хүчний тооцоолол:**

1 цагт 1 сорьц авах ажилтан 15 хүнд шинжилгээ хийж, нийт 8 цаг ажиллана гэж бодохоор 120 хүнээс шинжилгээ авна. Зуунмод сумын хэмжээнд 2 өдөр ажиллан, 1 өдөрт 2500 хүн үзэхээр төлөвлөнө. Ингээд өдөрт 2500 хүнээс шинжилгээг авахад 1 хүн 8 цагт 120 хүн үзнэ гэж тооцолоход 20 ажилтан ажиллахаар байна.

№	Ээлж	Ажиллах цаг	Ажилтны тоо	1 цагт шинжилгээ авах хүний тоо	4 цагт шинжилгээ авах хүний тоо	1 өдөрт шинжилгээ авах хүний тоо
1	Үдээс өмнө	09:00-13:00	20 ажилтан	300	1200	2400
2	Цайны цаг	13:00-14:00				
3	Үдээс хойш	14:00-17:00	20 ажилтан	300	1200	

**3. “Нэг Өрх-Нэг шинжилгээ”-ний цэгт ажиллах хүний нөөцийн тооцоо:**

№	Багийн гишүүд	Харьяалагдах байгууллага	Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл
1	Бүртгэлийн ажилтан	Тухайн багийн ажилтан	1 удаагийн халад, 1 удаагийн маск, малгай, нүүрний хаалт, бээлий, улавч
2	Сорьц авах ажилтан	Нэгдсэн эмнэлэг, ЭМГ, ӨЭМТ	Комбинзон, N95 маск, малгай, нүүрний хаалт /нүдний шил/, гутлын гадуурх углааш, бээлий
3	Ариутгагч	Нэгдсэн эмнэлэг, ЭМГ, ӨЭМТ	
4	Цагдаагийн албан хаагч	Цагдаагийн газар	1 удаагийн маск, нүүрний хаалт, бээлий
5	Онцгой байдлын албан хаагч	Онцгой байдлын газар	1 удаагийн маск, нүүрний хаалт, бээлий
6	Үйлчилгээний ажилтан	Тухайн байгууллага	1 удаагийн маск, нүүрний хаалт, бээлий

#### 4. Хамгаалах хувцас хэрэгслийн тооцоо:

№	Эд зүйлсийн нэрс	Хэмжих нэгж	Нэгж үнэ	2 хоногийн хэрэглээ	Нийт зардал төгрөг
1	Комбинзон	ш	18000	80	1,440,000
2	N95	ш	3000	80	240,000
3	Нэг удаагийн халад	ш	5,500	36	198,000
4	Нэг удаагийн маск	ш	100	160	16,000
5	Нэг удаагийн бээлий	хос	600	10,000	6,000,000
6	Нэг удаагийн малгай	ш	300	126	37,800
7	Нүүрний хаалт	ш	2,600	80	208,000
8	Гар халдваргүйжүүлэгч	мл	9,250	7	64,750
9	Хогийн уут шар, хар	боодол	5,500	5	27,500
10	80 хүн хоолны тооцоолол		5,000	400,000	800,000
11	2 өдрийн томилолт	хоног	12,000	80	1,920,000
12	Спирт 70%	л	9,000	6	54,000
13	Нойтон салфетик	боодол	3,500	12	42,000
14	Хуурай салфетик	боодол	1450	12	17,400
15	вакумтейнер	ширхэг	5000	250	1,250,000
16	Уян бамбар	ширхэг	5000	650	3,250,000
	<b>Нийт дүн</b>				<b>15,565,450</b>

\_\_\_оОо\_\_\_